



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/307

Арвайхээр сум

**Захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах
тухай**

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” 13 дугаар тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Уянга сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/147 дугаар захирамжийн хавсралтад Нийгмийн бодлогын мэргэжилтний 1 (нэг) орон тоог шинээр нэмж, нийт 26 (хорин зургаа) орон тоотойгоор тогтоосугай.

2. Тухайн орон тоог нэмэгдүүлэхэд шаардагдах цалингийн санг сумын батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Уянга сумын Засаг дарга (Б.Бямбадорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0584

D:My Doc. Zahiramj. Zasag darga